Сүмбэ хамба Ишбалжирын бүтээл дэхь гоо зүйн үзэл

Н.Батсайхан[1,3], Д.Цэрэндагва[2], Ө.Батчимэг[3]

[1]АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль
[2] АШУҮИС
[3]Оксфордын Их Сургууль, Их Британи
Цахим шуудан: batsaikhan.n@mnums.edu.mn

Түлхүүр үг:

Уламжлалт
Анагаах Ухаан
Гоо Зүй
Гоо Сайхны Мэс Засал
Анагаахын Гүн Ухаан
Бие
Сэтгэл
Оюуны Нэгдэл

Товч утга:

Удиртгал: Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788) нь XVIII зууны Монголын анагаах ухаан, соёл, сэтгэлгээний түүхэнд бие, сэтгэл, оюуны зохирлыг нэгдэл болгон үзсэн цогц философийг хөгжүүлсэн нэрт эрдэмтэн байв. Түүний 1751-1785 онд бичсэн эмнэлзүйн дөрвөн бүтээл нь хожим “Дөрвөн Рашаан” хэмээн алдаршсан бөгөөд өвчин эмгэгийн тухай төдийгүй хүний гоо сайхан, ёс суртахуун, ариун цэвэр, биеийн төгөлдөр байдлыг уялдуулсан “дотоод гоо зүйн” үзэл санааг тусгасан юм. Ишбалжир гадаад төрх, үнэр, үс, дуу хоолой зэрэг шинжүүд нь дотоод эрхтний тэнцвэр, сэтгэл зүйн болон оюуны төлөв, ариун цэврийн дэглэмтэй салшгүй холбоотой гэж үзсэн нь төвөд анагаах ухааны гурван гэм онолтой уялдсан үзэл юм. Тэрбээр гоо сайхны эмчилгээг зөвхөн биеийн үзэмжид бус, сэтгэл зүйн эрүүл байдал, нийгмийн ухамсар, ёс суртахуунтай холбон авч үзсэн. Тэрээр зохиолдоо хүүхдийн бие, оюуны хөгжлийг анхаарч, өнгө зүс сайжруулах эмчилгээ, билэг оюуныг хөгжүүлэх зан үйл, нэр хайрлах, буян хишгийг бататгах аргыг нарийвчлан заажээ. “Рашааны Цагаан Шүүдэр” бүтээлд тэмдэглэгдсэн хүүхдийн сэтэрхий уруул засах мэс ажилбар нь Монголд гоо заслын мэс заслын анхны бичмэл баримт бөгөөд Хятадын уламжлалт анагаах ухааны мэдлэгийг Монголын эмчилгээний дадлагатай уялдуулсан онцлогтой. Иймд Сүмбэ хамба Ишбалжир хүний гоо зүй, эмнэлзүйн мэдлэгийг нэгдмэл цогц болгон уялдуулж, “бие-хэл-сэтгэлийн нэгдэл” философийн хүрээнд эрүүл мэнд, гоо зүй, ёс суртахуун, амьдралын чанарыг нэгтгэн үзэх үндсийг бататгасан юм.

Үндэслэл: Хувь хүний гоо зүй, овор төрхийн асуудал Төвөд анагаах ухааны онолд хий, шар, бадган гурван махбодын хурмал хэлбэрээр буюу биед зөв зохистой тэнцвэрт байдлаар агуулагдсан бол тухайн хүн гоо сайхан, оюун ухаан төгөлдөр байдаг хэмээсэн байдаг.[7] Энэ үзэл нь Сүмбэ хамба Ишбалжирийн *Дөрвөн Рашаан* бүтээлд ч тодорхой тусгалаа олсон бөгөөд уг зохиол нь эмнэлзүйн судар төдий бус, харин гоо зүй, ариун цэвэр, ёс суртахууны нэгдлийг илтгэсэн соёл дамнасан философийн өв юм. Уг зохиол дахь хүний гоо зүй, ёс суртахуун, ариун цэвэр, биеийн төгөлдөр байдлыг судалсан судалгааны ажлууд ховор байгаа нь энэ судалгааг явуулах үндэслэл боллоо.

Судалгааны зорилго, арга зүй: Сүмбэ хамба Ишбалжир 1751-1785 оны хооронд эмнэлзүйн дөрвөн ном бичсэн[1] нь өнөө цагт *Дөрвөн Рашаан* хэмээн алдаршжээ. Энэхүү өгүүлэл нь эдгээр бүтээлүүдэд илэрхийлэгдсэн гоо зүйн үзэл, биеийн төгөлдөр байдлыг эмнэлзүйн болон мэс заслын практикт хэрхэн уялдуулсан болохыг судалж, үүгээр дамжуулан Монголын уламжлалт анагаах ухаанд гоо сайхны ойлголт хэрхэн шинжлэх ухааны, эмнэлзүйн хэлбэрт орон тусгагдсаныг илрүүлэхийг зорилоо. Тиймээс холбоотой хэсгүүд дэх бичвэрийн бүтэц, хэл найруулга, эмчилгээний нэр томьёо, хэрэглэгдсэн эм зүйн болон мэс заслын үгсэд судалгаа (textual analysis) хийж, түүнээс үүдэх эмнэлзүйн болон соёлын логикийг тодруулсан болно.

Сүмбэ хамбын гоо зүйн үзэл: Тус зохиолд хүний өнгө зүсийг сэргээх, нүүрний сэвх, сорвиос гадна хулмас, шивэр, муу үнэр зэрэг биеийн гадаад “бохирдол”-ыг арилгах олон төрлийн заавар орсон нь тухайн үед гоо сайхны ойлголт монгол анагаах ухааны эмчилгээний бүрэлдэхүүн хэсэг болон төлөвшсөнийг нотолдог. Жишээлбэл, “нүүрэнд гарсан цагаан цэцгийн шархыг

сорвигүй эдгээх”[5], “нүүрний сэвхийг арилгах”[5], “үс халзрахад үс ургуулах”[5] “сайхан үс ургуулах, сахал хөмсөгийг өтгөрүүлэх”[5], “амны болон биеийн үнэрийг арилгах”[5], “хулмас, шивэр дарах”[6] зэрэг жорууд нь зөвхөн гоо сайхны зорилготой бус, харин бие махбодын тэнцвэрийг хадгалах, ариун цэврийг сахихын тулд зориулагдсан ажээ. Тиймээс түүний зөвлөмжүүдэд дурьдагдсан эдгээр тохиолдлуудад хэрэглэх тосон түрхлэг, угаалга, үнэр дарагч, үс ургуулах зэрэг биеийн арчилгааны арга нь эмчилгээний нэгэн адил чухал байр суурь эзэлдэг.

Түүнчлэн “дуу хоолойгоо бүдүүрүүлэхийг хүсэх”[6], “дуу хоолойны өнгийг засаж яруу болгох”[5] зэрэг заалтууд нь зөвхөн гоо зүйн асуудал бус, харин хувь хүний өөрийгөө илэрхийлэх чадвар, нийгмийн харилцаанд оролцох соёлын хэлбэртэй холбогдож байна. Иймээс эдгээр нь Сүмбэ хамба хүний гоо сайхны ойлголтыг биеийн гадаад төрхөөс цааш өргөжүүлж, дуу хоолой, харилцааны соёлтой холбон ойлгож байсныг харуулна. Мөн “уруул омголтох, хумс болон арьс хагарах” зэрэгт тосон түрхлэг хэрэглэх[5] зэрэг нь дотор эрхтнүүдийн эмгэгүүдийн илрэлийг гоо сайхны талаас нь харгалзан үзэж эмнэн засаж байсны илрэл болно.

Өөрөөр хэлбэл, *Рашааны Цагаан Шүүдэр* бүтээлд агуулагдах эдгээр заалтууд нь биеийн өнгө зүс, үнэр, үс, дуу хоолой зэрэг бүх шинж чанар нь хүний дотор эрхтний эрүүл мэнд, биеийн ариун цэвэр, эрүүл биетэй шууд холбоотой гэсэн сэтгэлгээтэй уялдуулан авч үзсэн байна. Иймхүү эрүүл мэнд, гоо сайхан ба ариун цэврийн ойлголтыг нэгтгэн авч үзсэн нь Монгол анагаах ухаанд биеийн эрүүл оршихуйн соёлын философи бүхий үзэл баримтлал оршиж байсны илэрхийлэл болж байсныг гэрчилдэг.

Түүнчлэн Сүмбэ хамба Ишбалжирын анагаах ухааны бүтээлд хүний гоо зүй, билэг оюун, сэтгэлийн төлөвшлийг нэгтгэн илэрийлсэн нь хүүхдийн өвчний бүлэгт бичсэнээс анзаарагддаг. Тэрбээр шинэ төрсөн хүүхдийн өнгө зүс, билэг оюуныг төгөлдөржүүлэхийн тулд тусгай зан үйл, эмийн зааварчилгаа бичиж, төрсний дараах анхны үеэс нь эхлэн бие, сэтгэл, оюуны зохирлыг хангахын чухлыг онцолжээ. Хүүхдэд билэг дэмбэрэлтэй, сайхан нэр хайрлах нь хувь заяаны чиглэл, ирээдүйн зам мөрийг тодорхойлох үйлдэл гэж үзэхийн зэрэгцээ *“адаас гэтэлгэх”* ном уншуулж, буян хишиг, ивээл хамгааллыг бататгахыг зөвлөжээ. Мөн оюуныг хурцатгах, хүч чадлыг нэмэгдүүлэх, насыг уртасгах, түйтгэр, өвчнийг арилгах, өнгө зүсийг сайхан болгохын тулд зохих эм танг тус тус хэрэглэхийг бичсэн[5] нь зөвхөн эмчилгээний бус, хүний хөгжлийн тухай цогц үзэл санааг илэрхийлж байна.

Сүмбэ хамба Ишбалжирийн гоо сайхан, биеийн төгөлдөр байдлыг анхаарсан хандлага нь зөвхөн арьс, үс, үнэр зэрэг гоо сайхны арчилгааны зөвлөмжөөр хязгаарлагдахгүй, харин гадаад төрхийн гажиг засварлах мэс заслын төвшинд хүртэл илэрч байв. Үүний тод жишээ нь түүний *Рашааны Цагаан Шүүдэр* (1752) бүтээлд тэмдэглэгдсэн сэтэрхий уруулыг засах мэс ажилбар юм. Сэтэрхий уруулыг залгаж оёх мэс засал дэлхийн анагаах ухааны түүхэнд Хятадын эх сурвалжид анх тэмдэглэгджээ. Тухайлбал, МЭӨ 390 онд 18 настай Вэй Ён-чи (Wei Yongzhi) нэртэй залууд амжилттай хагалгаа хийгдсэн тухай түүхэн баримт бий бөгөөд энгийн дүр төрхтэй болсон тэрээр хагалгааны дараа төрийн болон цэргийн өндөр тушаалд дэвших боломжтой болж амжилтад хүрсэн байна[4]. Энэхүү мэдээлэл нь эртний соёлын хэмжүүрт хувь хүний гоо сайхан ба нийгэмд эзлэх байр суурь хоёр харилцан хамааралтай байсныг илэрхийлдэг. Сэтэрхий уруулыг засах энэ ажилбар 1872 онд Хятад хэлнээс Мэйрины зангі Коосикэ (XIX зуун)-ийн орчуулсан[2] “Бүхнээ Туслах Элдэв Зүйл Эмийн Найрлага” хэмээх номд “Урьд мэнэрэх эм түрхээд дараа сэтэрхий завсрын арьсыг өвчиж аваад торгон утсаар хамтатган оёод .... ” (1872: 15) хэмээн бичигдсэн нь хятад анагаахын эмчлэгч нар уг аргыг түүхийн урт удаан хугацааны туршид хэрэглэсээр ирсэнийг илтгэдэг.

XVIII зуунд Сүмбэ хамба Ишбалжир Хятад эмнэлгийн энэхүү уламжлалыг Монголын анагаах ухаанд дахин бүтээлчээр шингээсэн бөгөөд түүний бичсэн энэ төрлийн эмгэгийг эмчлэн засах заавар[5] нь тухайн үеийн гоо сайхны мэдрэмж, эмнэлгийн практикийг хослуулсан соёлын чухал баримт юм. Уг баримтыг нарийвчлан үзвээс Сүмбэ хамба Хятадын анагаах ухаанаас техникийн санаа авсан ч түүнийг шууд хуулбарласан бус, харин Монгол орны нөхцөл, уламжлалт мэдлэгт нийцүүлэн боловсронгуй болгосон нь анзаарагдана. Тэрээр эмчилгээнд баавгайн цөс түрхэж, илэг болон гурилан цавуутай эсгийгээр боолт хийхийг заажээ. Баавгайн цөс нь үрэвслийн эсрэг болон өвчин намдаах үйлдэлтэй[3] болох нь өнөөгийн шинжлэх ухаанаар нотлогдсон. Үүний зэрэгцээ хооллолт, амьдралын дэглэмийн зааврыг хавсаргасан нь тухайн эмчилгээний цогц байдлыг илтгэнэ.

Ийнхүү Ишбалжирийн бүтээлд дэх сэтэрхий уруулын мэс засал нь XVIII зууны Монголын анагаах ухаанд гоо сайхны мэдрэмж, эмчилгээний арга зүйн уялдаа гүнзгий шингэсэн байсныг харуулж, Сүмбэ хамба Ишбалжир хүний гадаад төрхийн зөв зохистой байдал нь хүний сэтгэл хангалуун байдал улмаар биеийн болон сэтгэл зүйн хувьд эрүүл оршихуйн илрэл гэж үзэж байсныг гэрчилдэг. Тиймээс *Рашааны Цагаан Шүүдэр* нь зөвхөн өвчнийг анагаах ухааны судар төдий бус, харин эрүүл мэнд, гоо сайхан, нийгмийн дүр төрхийн уялдаа бүхий цогц ойлголтыг илэрхийлсэн ойлголтуудыг давхар агуулжээ. Энэ нь хүний өнгө төрх, оюун ухаан, эрүүл мэнд гурвын уялдаа буюу “бие-хэл-сэтгэлийн нэгдэл” бүхий философийн суурь үзэлтэй нягт холбоотой болохыг харуулахын хамт физиологийн болон эмнэлзүйн асуудлын зэрэгцээ ёс суртахуун, амьдралын чанар, ёс зүйтэй нягт уялдсан цогц систем болох нь тодорхой ажиглагддаг.

Дүгнэлт: Сүмбэ хамба Ишбалжирын бүтээлүүд дэхь үзэл нь Монголын уламжлалт анагаах ухаанд гоо зүй, ёс зүй, эмнэлзүйн мэдлэгүүдийг нэгдэл болгон авч үзсэн сэтгэлгээний тод илэрхийлэл юм. Түүний *Дөрвөн Рашаан* бүтээл нь зөвхөн өвчнийг анагаах практик судар төдий бус, харин хүний бие, сэтгэл, оюуны оршлыг төгөлдөржүүлэх философийн үндэс, ёс суртахуун, хувь хүний төлөвшлийг нэгэн цогц системд авч үзсэн өргөн утга бүхий онцлог бүтээл юм.

Энэхүү үзэл санаа нь хүүхдийн бие, сэтгэл, оюуны хөгжлийг төрсөн үеэс нь эхлэн төлөвшүүлэх шаардлагатай гэдгийг тодотгож, хүний гоо зүй, оюун ухаан, ёс суртахууныг бие махбодийн зохирол, эрүүл мэндтэй нь холбон авч үзэхийг чухалчилжээ. Иймээс Сүмбэ хамба Ишбалжирын философи нь бүхэллэг анагаах ухааны онолын эх үндсийг Монголын уламжлалд биеийн гоо зүй, ёс зүй, эмнэлзүйн практикт уялдуулан хөгжүүлсэн соёл, танин мэдэхүйн үзэгдэл байсан гэж үнэлж болно.

Түүний бүтээл нь хүний амьдралын чанар, ёс суртахуун, хувь хүний төлөвшил, нийгмийн харилцаанд эзлэх байр суурь, гоо сайхан, сэтгэл зүйн эрүүл мэндийн ойлголтуудтай холбоотой цогц философийг агуулсан нь Монголын уламжлалт анагаах ухааны өвөрмөц онцлог, соёлын ач холбогдлыг тодорхой харуулж байна.

Ном зүй:

1. *Батсайхан, Норовын. 2021. Монгол анагаах ухаан: Зарим эх сурвалжийн нягтлан шинжлэл. Улаанбаатар: Ном Хур хэвлэл.*
2. *Коосикэ (XIX зуун)-ийн "Бүхнээ Туслах Элдэв Зүйлийн Эмийн Найрлага" (Бээжин бар, 1872). 15.*
3. *Li, Y.W., Zhu, X.Y., But, P.P., Yeung, H.W. 1995. Ethnopharmacology of bear gall bladder: I. Journal of Ethnopharmacology. 47 (1):27–31. doi: 10.1016/0378-8741(95)01249-d.*
4. *Ma, Kan-Wen. 2000. Hare-lip surgery in the history of traditional Chinese medicine. Medical History. 44 (04): 489 – 512. DOI: 10.1017/S0025727300067090,*
5. *Ишбалжир [ཞེ་ཤེས་དཔལ་འབྱོར]. 1994 [1752]. Рашааны Цагаан Шүүдэр, [Дөрвөн Рашаан གཙོ་རིག་གསུང་རྒྱུད་བཞིའི་ནང་བཤད་པ]. Силин [ཟི་ལིང་]: Хөх Нуурын Хэвлэлийн Хороо [མཚོ་སྔོན་མི་རིགས་དཔེ་སྐྲུན་ཁང་]*.
6. *Ишбалжир [ཞེ་ཤེས་དཔལ་འབྱོར]. 1994 [1759]. Рашааны Дусал, [Дөрвөн Рашаан གཙོ་རིག་གསུང་རྒྱུད་བཞིའི་ནང་བཤད་པ]. Силин [ཟི་ལིང་]: Хөх Нуурын Хэвлэлийн Хороо [མཚོ་སྔོན་མི་རིགས་དཔེ་སྐྲུན་ཁང་]*.
7. *Ютог Ёндонгомбо [གཡུ་ཐོག་ཡོན་ཏན་མགོན་པོ]. 2005 [XII зуун]. Дөрвөн Үндэс [རྩ་བ།]. Лхас: Төвөдийн Ардын Хэвлэлийн Хороо [བོད་སྤྱི་མི་དམངས་དཔེ་སྐྲུན་ཁང་] 289*

The Aesthetic Views in the Works of Sümbe Khamba Ishbaljir

Batsaikhan N[1,3], Tserendagva D[2], Batchimeg U[3]
[1]International School of Mongolian Medicine, Mongolian National University of Medical Sciences
[2]Mongolian National University of Medical Sciences
[3]University of Oxford, United Kingdom
E-mail: batsaikhan.n@mnums.edu.mn

Abstract:

Background: Sumpa mkhanpo Ye shes dpal 'byor (1704-1788) was a prominent scholar in 18th-century Mongolian medicine, culture, and thought, who developed a comprehensive philosophy integrating the harmony of body, mind, and spirit. His four clinical works, written between 1751 and 1785 and later known as the *Four Medicinal Elixirs*, addressed not only diseases but also human beauty, ethics, hygiene, and physical well-being, reflecting a concept of "inner aesthetics." Ye shes dpal 'byor regarded external features such as appearance, scent, hair, and voice as inseparably linked to the balance of internal organs, psychological and intellectual states, and hygienic practices, in accordance with the Tibetan medical theory of the three humours. He viewed cosmetic treatments not merely as enhancements of physical appearance but as practices supporting psychological health, social awareness, and moral development. He emphasised the holistic care of children from early life, detailing methods to improve complexion, cultivate intelligence, assign meaningful names, and reinforce virtues, illustrating his systematic approach to human development. Furthermore, his work *The White Dew of Medicinal Elixir* documents surgical correction of cleft lips in children, representing the earliest written record of cosmetic surgery in Mongolia and demonstrating a creative integration of Chinese medical knowledge with local medicinal resources and practices. Thus, Sumpa mkhanpo Ye shes dpal 'byor uniquely combined knowledge of aesthetics and clinical medicine, implementing innovative concepts in Mongolian traditional medicine. His approach linked beauty treatments with personal value, mental health, social conscience, and ethical cultivation, grounded in a philosophy of the "unity of body, speech, and mind," and established a framework for integrating health, aesthetics, morality, and quality of life in Mongolian medical thought.

Key words: Mongolian Traditional Medicine, Aesthetics, Aesthetic Surgery, Medical Philosophy, Unity of Body, Mind, and Intellect.